



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 20

Мандалговь

Хөрөнгө акталж,
данснаас хасах тухай

Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.3 заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2.1, 5.8.а, 5.8.д дэх заалтыг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Дэрэн сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 14,539,408 /Арван дөрвөн сая таван зуун гучин есөн мянга дөрвөн зуун найман төгрөг/-ний анхны өртөгтэй, 10,578,536.00 /Арван сая таван зуун далан найман мянга таван зуун гучин зургаан төгрөг/-ний хуримтлагдсан элэгдэл бүхий 4 айлын орон сууцны нэг бүрийн дуудлага худалдааны доод үнийг 1,000,000.00 /Нэг сая/ төгрөг, 2,651,500.00 /Хоёр сая зургаан зуун тавин нэгэн мянга таван зуун төгрөг/-ний анхны өртөгтэй, 493,473.00 /Дөрвөн зуун ерэн гурван мянга дөрвөн зуун далан гурван төгрөг/-ний хуримтлагдсан элэгдэл бүхий сауны дуудлага худалдааны доод үнийг 2,000,000.00 /Хоёр сая/ төгрөгөөр тогтоож эзэмшил газрын хамт худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө худалдсаны орлого 100080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар /С.Ууганбаяр/-т даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ц.Мөнгөнцэцэжид үүрэг болгосугай.

ДАРГА С.СҮХБААТАР

